

**02.3.1.ХОТ, ТОСГОНЫ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ШАЛГАХ  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Шалгуулагч этгээдийн этгээдийн нэр:  
 Хяналт шалгалт хийх объектын нэр:  
 Шалгуулагч этгээдийн регистрийн дугаар:  
 Хяналт шалгалтын удирдамжийн дугаар:  
 Хяналт шалгалт хийж эхэлсэн огноо: ...../...../.....  
 Хяналт шалгалт дууссан огноо: ...../...../.....

Хяналт шалгалт хийсэн огноо: ...../...../.....

Хууль сахин  
мөрдөлтийн хувь:

Эрсдэл үүсэх  
магадлал

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэл- ийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1	2	3	4	5	6	
<b>Хот байгуулалтын баримт бичгийн бүрдэлтэй холбогдсон асуудлууд</b>			<b>0</b>	<b>226</b>	<b>0</b>	<b>0</b>
1	Хот байгуулалтын тухай хуулийн 11.2	Хот байгуулалтын баримт бичгийн зохиогч нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй.				
2	Хот байгуулалтын тухай хуулийн 5.1.2, 5.1.3, 5.1.4	МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон хотыг шинээр байгуулах, татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргасан, чөлөөт бүсийн хилийн цэсийг баталж, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан.	0	5		

3	Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.4, 9.1.4, 16.1, Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм 3.1.2	Хот, тосгон, төв суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгол, шинэчлэл хийх асуудлыг санаачлан зохион байгуулсан, хот, шинэ хороолол, хотхон, гэр хороолол, хотын хуучин хэсгийг шинэчлэн байгуулах шийдвэр гаргасан.	0	5		
4	"Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм"-ийн 2.1.1, 2.1.2, 2.1.5, 3.3, 3.4	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах даалгаврыг "Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм"-ийн дагуу боловсруулж, баталсан.	0	10		
5	Хот байгуулалтын тухай хуулийн 11.3	Хот байгуулалтын баримт бичгийг ажил гүйцэтгэх гэрээний дагуу боловсруулсан.	0	3		
6	ХБТХ-ийн 17 дугаар зүйл, ХСГДХТХ-ийн 11.1.5	Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэд болон мэргэжлийн хүмүүсээс санал авсан.	0	5		
7	Хот байгуулалтын тухай хуулийн 20 дугаар зүйл, ХББББЗЭХД-ийн 4.3.6, "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага" MNS 6055: 2009, "Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага" MNS 5682: 2006, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056: 2009	Тухайн хот, тосгон, төв суурин газрын эдэлбэр газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцлийг хангасан хот байгуулалтын шийдэл гаргасан.	0	10		
8	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар /БД30-103-21/-ын 4 дүгээр бүлэг	Хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүх үе шатны зураг төслийн бүрдэлтэй.	0	10		
9	ХБТХ-ийн 16.2, 18 дугаар зүйл, ХСГДХТХ-ийн 11.1.5, 14.5,	Хот байгуулалтын баримт бичгийн талаарх аливаа шийдвэрийг тухай бүр олон нийтэд мэдээлсэн.	0	5		

10	ХБТХ-ийн 10.1.2,ХБББЗЭХД-ийн 3.2, Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм 3.1.1	Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийж батлахаас өмнө хот байгуулалтын баримт бичгийн үндсэн болон инженерийн шугам сүлжээний шийдлийн талаар гүйцэтгэгч эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектортой зөвшөөрөлцсөн.	0	5		
11	МУ-ын ЗГ-ийн 2010 оны 102 дугаар тогтоолын 1-р хавсралт, ЗГ-ын 2014 оны 8 р тогтоолын 1-р хавсралт	Хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлагын дагуу боловсруулсан.	0	10		
12	МУЗГ-ын 2014 оны 8-р тогтоолын 1, 2-р хавсралт	Хяналт шалгалтын бүс, логистикийн бүс, суурьшлын бүсүүдэд төлөвлөх шаардлагатай барилга байгууламжийг тусгасан.	0	20		
13	Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.5, 11.6, ХБББЗЭХД-ийн 4.4	Хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гаргуулсан.	0	10		
14	Хот байгуулалтын тухай хуулийн 5.1.4, 5.1.5, 6.1.4, 6.1.6, 6.1.7, 8.1.5	Хот, тосгон, төв суурин / <i>аймаг, нийслэл сум, дагуулт хот, аялал жуулчлал, онцгой объект, чөлөөт бүс</i> / газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан.	0	10		
15	ХБТХ-ийн 7.1.12, 8.1.1	Хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан.	0	10		
16	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11.1.1, 14.1	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шийдвэр гаргасан.	0	5		
17	"Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам"-ын 4.1, 4.2	Хот, суурин газарт төсөл хэрэгжүүлэх талбайг сонгоход тавигдах жишгийг баримталсан.	0	5		

18	ХСГДХТХ-ийн 10.1.1, 20.1.2, 20.2, "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам"-ын 2.2	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг баримтлан төсөл хэрэгжүүлэх талбайн байршил, хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоож, шийдвэр гаргасан.	0	5		
19	"Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын 4.5, 4.6, 4.7	Үнэлгээний хорооны дүгнэлт гаргасан.	0	3		
20	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11.1.3, 19 дүгээр зүйл, "АШХНЗОСББШБҮАЖ"-ын 4.8	Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсныг батламжилсан захирамж гарган, гурван талт гэрээ байгуулах эрх олгосон.	0	5		
21	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 16.2, "АШХНЗОСББШБҮАЖ"-ын 3.2	Аймаг, нийслэлийн Засаг дарга ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр барилга баригдаж ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд түр түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан.	0	5		
22	"Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын 3.4	Орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах тухай хүсэлтээ баталсан загварын дагуу гаргаж, 14 хоногийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлсэн.	0	10		
23	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 16.4, "АШХНЗОСББШБҮАЖ"-ын 3.6	Аймаг, нийслэлийн Засаг дарга нь холбогдох журмын дагуу төсөл хэрэгжүүлэх талбайг сонгож, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, шийдвэрлүүлсэн.	0	10		

24	"Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын 3.8	Орон сууц өмчлөгчийн хүсэлт, барилгын техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга орон сууцыг буулгах, дахин төлөвлөх, шинээр орон сууц барих шийдвэрийг гаргасан.	0	10		
25	АШХНЗОСББШБҮАЖ-ын 3.9	Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллага нь сонгосон талбайд төсөл хэрэгжүүлэх ажлын даалгаврыг 14 хоногт боловсруулж, тухайн шатны Засаг дарга ажлын 3 өдрийн дотор баталсан.	0	10		
26	ХСГДХТХ-ийн 11.2, 24.1, "АШХНЗОСББШБҮА-ны журам"-ын 5.4	Төсөл хэрэгжүүлэхэд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга, газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч оролцсон гурван талт гэрээ байгуулсан.	0	10		
27	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11.1.4, 23.1.5,	Төсөл, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч нар гэрээний биелэлтийг хамтран дүгнэсэн, гэрээний хэрэгжилтийг хангуулсан.	0	5		
28	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.7.1, 14.7.2	Төсөл хэрэгжүүлэхдээ төслийн үе шат, төлөвлөлтийн болон шийдвэр гаргуулах үе шатыг баримталсан.	0	5		
29	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.7.3г, 15.4, 20.1.2, "АШХНЗОСББШБҮА-ны журам"-ын 7.2	Хот, суурин газрын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан зураг төсөл боловсруулж батлуулсан.	0	10		

30	"Барилгын зураг - Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ" MNS 5873 : 2008, "Барилгын зураг төслийн баримт бичгийн систем Ерөнхий төлөвлөгөө, зам тээврийн зургийн таних тэмдэг, дүрслэлүүд" MNS 3237 : 1989	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот, суурин газрыг дахин төлөвлөлтийн төслийн ажлын зурагт барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ зэргийг томъёолон тэмдэглэсэн, таних тэмдэглэгээг стандартын дагуу тэмдэглэсэн.	0	10		
<b>Хот байгуулалтын үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлууд</b>			<b>0</b>	<b>613</b>	<b>0</b>	<b>0</b>
31	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 1.2	Тухайн хот, тосгон, төв суурин газрын барилгажилтыг хэрэгжүүлэх явцад мэргэжлийн экспертизийн дүгнэлт хийлгэж баталгаажсан ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын баримт бичгийн дагуу гүйцэтгэсэн.	0	5		
32	Хот байгуулалтын тухай хуулийн 14.1, "Хот, тосгон бусад суурин газрын авто зам, гудамж талбайн гэрэлтүүлэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS 6846 : 2020	Орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн.	0	20		
33	Хот байгуулалтын тухай хуулийн 14.2,	Орон сууц, олон нийтийн бүсэд орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж төлөвлөж, барилгажуулсан.	0	20		
34	Хот байгуулалтын тухай хуулийн 14.2,	Үйлдвэрлэлийн бүсэд үйлдвэр, нийтийн аж ахуй, агуулахын зориулалттай барилга байгууламж, тэдгээрийн үйл ажиллагааг хангах инженерийн болон зам тээврийн дэд бүтцийн барилга байгууламжийг төлөвлөж барилгажуулсан.	0	20		

35	Хот байгуулалтын тухай хуулийн 14.3, Хот, тосгон бусад суурин газрын авто зам, гудамж талбайн гэрэлтүүлэг. Техникийн ерөнхий шаардлага	Инженерийн шугам сүлжээний болон зам тээврийн бүсэд төмөр зам, усан болон авто тээвэр, агаарын тээвэр, инженерийн /цэвэр, бохир усны, дулаан, холбоо, цахилгааны гэх мэт/ шугам сүлжээний барилга байгууламжийг төлөвлөсөн.	0	20		
36	Хот байгуулалтын тухай хуулийн 14.4, "Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах" MNS ISO 11091 : 2007	Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүсэд хот орчмын ой, ойн хамгаалах зурвас, амралт, сувилал, усан сан, цэцэрлэгт хүрээлэн, спортын цогцолбор, наран шарлагын газар зэрэг олон нийтийг хамрах амралт зугаалгын үйл ажиллагааг зохион байгуулахад зориулагдсан орон зайн задгай орчин, түүнчлэн байгалийн дархан цаазат болон онцгой хамгаалалттай газар нутгийг төлөвлөсөн.	0	20		
37	Хот байгуулалтын тухай хуулийн 14.5	Хөдөө аж ахуйн бүсэд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх газар, хөдөө аж ахуйн чиглэлийн барилга байгууламж байрлуулж, хадлангийн зориулалтаар ашиглах нутаг дэвсгэрийг төлөвлөсөн.	0	20		
38	Хот байгуулалтын тухай хуулийн 14.6	Зуслангийн бүсэд иргэд зуны улиралд түр хугацаагаар суурин амьдарч болох хотын төвөөс зайдуу орших төвлөрсөн дэд бүтэцгүй суурьшлын газар нутгийг төлөвлөсөн.	0	20		
39	Хот байгуулалтын тухай хуулийн 14.7	Тусгай зориулалтын бүсэд улсын нөөц газраас гадна иргэний хамгаалалт, батлан хамгаалахын зориулалттай, түүнчлэн хатуу хог хаягдлын цэг, шарилын газар, цогцос чандарлах үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийг төлөвлөсөн.	0	20		
40	БНБД 30-01-04-ийн 2.3, 9.8, БНБД 30-02-07-ийн 2.11	Тухайн хот, тосгон, төв суурин газрын суурьшлын бүсийг зонхилох салхины эхэнд, үйлдвэр аж ахуйн бүсийг зонхилох салхины дор байрлуулсан.	0	10		

41	БНБД 30-01-04-ийн 3.4, БНБД 30-02-07-ийн 2.11, 3.19	Үйлдвэрийн газар, үйлдвэрийн зангилааны ерөнхий төлөвлөгөөнд тавигдах 10 болон өргөтгөх, шинэчлэх үйлдвэрийн 6 шаардлагыг төлөвлөлтөнд тусгасан, түүний дагуу барилгажуулсан.	0	5		
42	Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө БНБД 30-02-07-ийн 3.8, 3.9, 3.10	Үйлдвэрийн талбайг үйл ажиллагааны ашиглалтаар нь заводын өмнөх зурвас, үйлдвэрлэлийн, туслах, агуулахын, олон нийтийн төв, үйлдвэрийн талбай, туслах үйлдвэрлэл ба аж ахуйн нэгдсэн объектын бүсүүдэд хуваасан.	0	5		
43	БНБД 30-01-04-ийн 3.6-3.9, 9.8-ийн тайлбар 1, БНБД 30-02-07-ийн 2.12	Үйлдвэрийн ба орон сууцны суурьшлын бүсийн хооронд ариун цэвэр-хамгаалалтын зурвас гаргасан.	0	10		
44	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 3.5, Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө БНБД 30-02-07-ийн 2.12	Хорт бодис ялгаруулдаггүй, бохирдолгүй нормын зөвшөөрөгдөх хэмжээнд дуу шуугиан гаргадаг үйлдвэр, аж ахуйн газруудыг суурьшлын бүсэд байршуулахдаа орон сууцны барилга, амралт зугаалгын бүс, эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэцэрлэгээс 50м-ээс багагүй зайд байрлуулсан.	0	20		
45	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 3.14	Улсын нөөцийн агуулах, 1-р группийн нефть болон нефтийн бүтээгдэхүүний дамжлага бааз, шингэн хийн агуулах, шатах дэлбэрэх материалын агуулах, хүчтэй хот бодисуудын суурь агуулах, хүнсний бүтээгдэхүүний суурь агуулах, бордоо ба үйлдвэрийн түүхий эд, ойн болон барилгын материалын агуулахыг хот, тосгоны нутаг дэвсгэрийн хилийн гадна эрүүл ахуй, гал түймрийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан тусгай зориулалттай агуулахуудын бүсэд байрлуулсан.	0	10		



46	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 4-р бүлэг, 4.2, 2.10,	Тухайн хот, тосгон, төв суурин газрын барилгажсан нутаг дэвсгэрийн 40%-иас багагүй цэцэрлэгжүүлсэн, сууцны хорооллын барилгажсан нутаг дэвсгэрийн 25% нь багагүй нь цэцэрлэгжүүлсэн.	0	20		
47	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 2.1, хавсралт 4, 5, 6	Суурьшлын бүсийн архитектур-орон зайн төлөвлөлтийг боловсруулахдаа галын аюулаас хамгаалах шаардлага, хот, тосгоны нутаг дэвсгэр ашиглалт, барилгажилт болон хүн амын төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүд, хүн амын багтаамжийг тооцон зарчмын дагуу төлөвлөсөн.	0	20		
48	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 5.4, 2.1-ийн тайлбар 4	Олон нийт, иргэний барилга байгууламжийн хүн амд үйлчлэх хүрээний зай хэмжээг тооцож төлөвлөн барилгажуулсан.	0	15		
49	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 2.5	Нам давхар сууцны хороололд тавигдах 3 зарчмаар байрлуулан төлөвлөсөн, түүний дагуу барилгажуулсан.	0	10		
50	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 2.8	Орон сууцны хорооллын эдэлбэр газарт 2 зурвастай зам болон барилгын орцны орчимд замын өргөн 5.5 м-ээс багагүй байхаар төлөвлөсөн.	0	5		
51	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 2.15	Хот хоорондын чанартай автозам болон хөдөө аж ахуйн техник хэрэгсэл зорчих зам, мал тууврын замыг суурьшлын бүсийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрхөөргүй төлөвлөсөн.	0	10		
52	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 2.18	Хөдөөгийн суурин дахь секцлэн барьсан орон сууцанд оршин суугчдын мал аж ахуйд зориулсан эдлэн газар болон мал аж ахуй эрхэлдэг аж ахуйтны хорооллыг суурьшлын бүсийн гадна орчинд төлөвлөсөн.	0	10		
53	БНБД 30-01-04-ийн 6-р бүлэг	Хот, тосгоны гудамж, замын сүлжээг тавигдах шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	20		

54	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 6.30, 6.32	Суудлын автомашины түр зогсоолын хүчин чадлыг суудлын автомашины паркийн 70%-ийг хамрахаар тооцож төлөвлөх ба сууцны хороолод 25%, үйлдвэр аж ахуйн агуулахын бүсэд 15%, хотын олон нийтийн, нийгмийн үйлдвэрлэл үйлчилгээний төрөлжсөн төвүүдэд 15 %, нийтийн амралтын бүсэд 15% байхаар тооцож төлөвлөсөн.	0	10		
55	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 7.1, 7.2	Ус болон бохир ус цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээ, хүчин чадлаас нь хамааруулан тооцож төлөвлөсөн.	0	10		
56	ХБТХ-ийн 21 дугаар зүйл, ХСГДХТХ-ийн 14.4.2	Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ инженерийн бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр ус, цахилгаан, дулаан хангамжийн найдвартай эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, гол зам, холбоожуулалтын сүлжээнээс эхлэн барьж байгуулах ажлыг хэрэгжүүлсэн.	0	10		
57	Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.2	Орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэр, үйлдвэрийн туслах барилга байгууламжийн хоорондын гал тусгаарлах зайг тооцсон.	0	20		
58	Хот байгуулалтын тухай хуулийн 24.1.4	Тухайн хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ инженер-геологийн судалгаа, зураг төсөлтэй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барьж, өргөтгөн, шинэчилсэн.	0	20		

59	Хот байгуулалтын тухай хуулийн 23.1	Тухайн хот, тосгон, суурин газрын дараахь бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон: 1.түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд; 2.усны эх үүсвэр, усан сан бүхий газрын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд; 3. ашигт малтмалын орд бүхий бүсэд; 4. байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай бүсэд; 5.экологийн онцгой болон сүйрлийн бүсэд; 6.газар дээрх болон доорхи дэд бүтэц бүхий бүсэд.	0	10		
60	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 9-р бүлэг	Тухайн хот, тосгон, суурин газрын хүрээлэн буй орчин, түүх соёлын дурсгалыг хамгаалах ажлыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэсэн.	0	5		
61	Хот байгуулалтын тухай 10.1.4, 25, 26 дугаар зүйл, АНХЕАД-ийн 3.1.4, Хот байгуулалтын кадастр БД 14-102-19	Хот суурины нутаг дэвсгэрт хот байгуулалтын кадастр хөтөлсөн, хот байгуулалтын архивын санг бүрдүүлсэн.	0	10		
62	Хот байгуулалтын тухай хуулийн 19.2, АНХЕАД-ийн 3.1.10	Тухайн хот, тосгон, төв суурин газрын эдэлбэр газрыг хот байгуулалтын баримт бичиг болон хот байгуулалтын норм ба дүрэм, журамд тусгагдсаны дагуу барилгажилт, газар ашиглалтын үйл ажиллагааг явуулж, хяналт тавьсан.	0	20		
63	Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.1 Орон сууцны тухай хуулийн 9.1	Орон сууц, түүний дэд бүтцийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх арга хэмжээг орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.	0	10		

64		Тухайн барилга байгууламжийн газар олголтын шийдвэрийг гаргахдаа хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний үндсэн шаардлага, үе шатны зорилт, эдэлбэр газрын зориулалт, инженерийн шугам сүлжээний даац, технологийн горим зөрчөөгүй.	0	10		
65	ХБТХ-ийн 24.1.6, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 7.10	Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын гадна талд төлөвлөсөн.	0	20		
66	Хот байгуулалтын тухай хуулийн 24.1.3	Тухайн олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж бариагүй, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагааг явуулаагүй.	0	20		
67	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11.1.4, 23.1.5	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн гэрээний хэрэгжилтийг хангуулж, дүгнэсэн.	0	5		
68	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.4.1	Хот, суурин газар, дүүрэг, хорооллын чанартай инженерийн бэлтгэл арга хэмжээ, батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах зориулалт бүхий барилга байгууламж төлөвлөж, барьсан.	0	10		
69	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.7.3г, 15.4, 20.1.2	Хот, суурин газрын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулан батлуулж, түүний дагуу барилга байгууламж барих үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу хэрэгжүүлсэн.	0	10		
70	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 18.1	Гэр хороололд инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, орон сууц, нийтээр ашиглах барилга байгууламж барих, тохижилт хийх, эдийн засаг, нийгэм, байгаль орчны зохистой харьцааг хангах зорилгоор гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулсан.	0	10		

71	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 23.1.4	Сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн гаргасан хүсэлтийг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж, төлөвлөсөн.	0	5		
72	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 23.1.8	Төсөл хэрэгжүүлэхэд байгаль орчны, эрүүл ахуйн, аюулгүй байдлын болон бусад холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартын шаардлагыг мөрдсөн.	0	5		
73	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.7.3, 26.1, 26.4	Төслийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын хороог байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьсан.	0	3		
74	Хот байгуулалтын тухай хуулийн 12.3, 19.2	Чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө нь хот байгуулалтад тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангасан худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал эрхлэх, дэд бүтцийн хангамж нөхцлийг тооцож төлөвлөж, барилгажуулсан.	0	10		
75	Хот байгуулалтын тухай хуулийн 22.1.1	Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага нь хот байгуулалтын тухай хууль тогтоомж, норм ба дүрэм, журам, стандартыг дагаж мөрдсөн.	0	5		
76	Хот байгуулалтын тухай хуулийн 24.1.5	Батлагдсан төв, суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тэдгээрийг зөрчих, зөвшөөрөлгүй дур мэдэн өөрчлөөгүй.	0	20		
77	Хот байгуулалтын тухай хуулийн 24.2	Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шийдвэрт хамрагдсан тухайн газар нутагт газар эзэмших, ашиглах эрх олгох болон хот байгуулалтын бусад үйл ажиллагаа явуулахыг тодорхой хугацаагаар түр зогсоосон газарт хот байгуулалтын үйл ажиллагаа явуулаагүй.	0	20		
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>839</b>	<b>0</b>	<b>0</b>

**БАТАЛГААЖУУЛАЛТ**

<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>